



**ДУНГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 284

Мандалговь


**Хөрөнгө худалдах тухай**

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 5.2.1, 5.8.а заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Цагдаагийн хэлтсийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 12'000'000 /арван хоёр сая/ төгрөгийн анхны өртөгтэй, элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нөхсөн 12 мотоциклыг худалдан авах хүсэлт гаргасан хүнд шууд худалдах, 20'200'000 /хорин сая хоёр зуун мянга/ төгрөгийн анхны өртөгтэй, элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нөхсөн <sup>УБҮ 02-41</sup> Дуа 90-00, Дуа-80-88 улсын дугаартай 2 автомашиныг хавсралтын дагуу дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга П. Очирбатад үүрэг болгосугай.

3. Худалдсан эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу данс бүртгэлээс хасахыг Цагдаагийн хэлтсийн дарга Л.Гүндсүрэнд даалгасугай.

ДАРГА  С.БУДЖАВ

Аймгийн ИТХТ-ийн 2014 оны 18 сарын 18 өдрийн тогтоолын хавсралт



Худалдах хөрөнгийн жагсаалт

Д/д	Нэр	Тоо ширхэг	Ашиглалтад орсон огноо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Үлдэгдэл өртөг	Худалдах дээд үнэ /1 бүрийн үнэ/	Худалдах доод үнэ /нийт үнэ/
1	УАЗ-469 автомашин	2	2007.01.01	10'000'000	20'200'000	-	3'000'000	6'000'000
2	Мотоцикл	12	2011.07.22	1'000'000	12'000'000	-	90'000	1'080'000